


2022.04.26



Баянтал сумын Засаг даргын Тамгын газрын  
04 дүгээр сарын тайлан

## Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Сумын Засаг дарга Г.Анхбаяр газрын талаарх мэдээллийг цахимаар хүргэж, мэдээлэл өгөв



2022.04.21-22-ны өдрүүдэд хөдөөгийн малчдаараа явж хаваржилтын цагийн байдалтай танилцаж, малчидтай уулзаж, Мал амьтаны Гоц Халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын дархлаажуулалтын ажлын зөвлөмж өгч, үүрэг чиглэл өглөө.

### -АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИСС ХУРАЛДЛАА./2022.04.23/

Онцгой комиссын 02 тогтоол, Хүнс Хөдөө Аж Ахуй, Хөнгөн үйлдвэрийн Сайдын 01 албан даалгаврын хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд ХХААХҮ-ийн Дэд Сайд Г.Батсууриар ахлуулсан ажлын хэсэг Говьсүмбэр аймгийн онцгой комиссын гишүүдтэй уулзаж, мал амьтны гоц халдварт шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын дархлаажуулалтын ажлын талаар онцгой комиссын гишүүдэд зөвлөмж өгч, үүрэг чиглэл өглөө.



Сумын хэмжээнд эрсдэлт нөхцөлд амьдардаг бүртгэлтэй 60 хүүхдийн гэрээр орж танилцаад, 4 өрхийн 16 хүүхдэд 4-р сарын 4-ний өдөр Хүүхэд, гэр бүл залуучуудын хөгжлийн газартай хамтран хүнсний тусламж үзүүлэв.

Нэг өрхийн хүнсний багцад 25 кг гурил, 10 кг будаа, 5 л ургамлын тос, саван, маск багтсан. 4-р сарын 5-ны өдөр Боржигон чуулгад Говьсүмбэр Аймгийн Гэр бүл Хүүхэд залуучуудын хөгжлийн газраас байгууллагын эцэг эхийн зөвлөлүүдэд чиглэсэн сургалтанд Ерөнхий боловсролын 4-р сургуулийн эцэг эхийн зөвлөл, ЗДТГазрын эцэг эхийн зөвлөл хамрагдсан.

3-р сарын 29-ний өдөр Сумын Засаг даргын Тамгын газрын Иргэний танхимд өглөөний 09 цагаас орой 19 цаг хүртэл аймгийн Нэгдсэн эмийн сан ард иргэдэд эмийн үйлчилгээг үзүүлэв.

Сумын хамтарсан багийн нарийн бичгийн дарга, хэсгийн цагдаа нар хамтран шөнийн эргүүлийг өнгөрсөн долоо хоногт 2 удаа хийж ажилласан



2022 оны 03 дугаар сарын 31-ны байдлаар 46,476.0 мянган төгрөг төлөвлөгөө батлагдсанаас гүйцэтгэлээр 31,236.9 мянган төгрөг буюу 67 хувь буюу 15,239.1 мянган төгрөгөөр орлого дутуу орсон байна.

Баянтал сумын нэгтгэлийн/ОН/ төлөвлөгөө 514,250.0 мянган төгрөг, гүйцэтгэл 276,625.4 мянган төгрөг байна. Үүнээс үндсэн цалин,унаа хоол,нэмэгдэл урамшуулалд 96,548.4 мянган төгрөг НДШ 8,342.7 мянган төгрөг зарцуулсан байна.

Баянтал сумын нэгтгэлийн /ОН/ өглөг 24,304.4 мянган төгрөг , авлага 3,576.8 мянган төгрөг байна.

Тайлант онд өглөгийн үүссэн шалгаан нь 2022 оны 1 сараас Халаалт, цэвэр бохир усны үнэ нэмэгдснээс болж 1 дүгээр улирлын байдлаар 16,304.1 мянган төгрөгөөр өглөг нэмэгдсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 9 төсвийн байгууллага, сангийн санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 6 байгууллагад дүгнэлт гаргаж, 3 байгууллага түүвэрт хамрагдсан байна. Аудитаар хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “зөрчилгүй-4” / 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, ЗДТГ, ОНХС, 4 дүгээр сургууль,/ “хязгаарлалттай-2” /4 дүгээр цэцэрлэг, Эрүүл мэндийн төв/ дүгнэлт авсан байна. Санхүүгийн тайлангийн аудитын асуудлаар нийт 330.2 сая төгрөгийн алдаа, зөрчил илрүүлснээс 90.2 сая төгрөгийн 22 алдааг аудитын явцад залруулж, 3.6 сая төгрөгийн 7 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 226.3 сая төгрөгийн 9 зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлж, 10.2 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 9 зөвлөмжийг өгсөн байна.

Сумын 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаар “Зөрчилгүй” санал дүгнэлт авсан.



Аймгийн МХГ, ХАУТанхимтай хамтарч худалдаа, нийтийн хоолны үйл ажиллагаа эрхлэгчид, ААН, төсөвт байгууллагыг хамруулсан “Хүнсний аюулгүй байдал”, “Ажлын байрны стандарт” сургалтыг зохион байгуулсан

- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний сэргээн засах үйлчилгээний бүлгийн төсөлд “Өв соёл” төсөл дэмжигдэж, гэрээгээ байгуулав.
- 2022 оны 04-р сарын 07-08-ны өдрүүдэд Азийн хөгжлийн банк, ХНХЯам, ХХҮЕГ хамтран зохион байгуулж байгаа “Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийн чиглэл чадавхижуулах сургалтанд амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүд оролцлоо.
- “Нэг өрх- нэг ажлын байр” арга хэмжээний хүрээнд 28 өрхийн судалгааг гаргалаа.
- Сумын Ахмадын хороо 2021 оны үйл ажиллагааныхаа тайланг тавьж, 9 тэргүүлэгч, хяналтын хорооны 3 гишүүнээ сонголоо мөн Ахмадын хорооны даргаар Л.Лхагвасүрэн 69,8 % хувийн санал авч улиран сонгогдлоо.



ADB

Үр дүнтэй нийгмийн халамжийн системийн чадавхи бэхжүүлэх нь: ТТ 9893-МОН

Нийгмийн халамжийн бодлогын шинэчлэлийн чиглэл онлайн сургалт

2022 оны 4 сарын 7

Oxford Policy Management





## Удирдлага зохион байгуулалтын ажлын хүрээнд:

Сумын ИТХурлаас ирүүлсэн “Бэлчээр хамгаалах журам”-ын цахим хувилбар, нөлөөллийн шинжилгээний тайланг 2022.04.19-ны өдөр хүргүүлсэн.



•Сум хөгжүүлэх сангийн 2020-2021 оны баримтуудад Аймгийн ХХААГ-ийн дотоод аудитад орж, шаардлагатай мэдээлэл, тайлбарыг гаргаж хүргүүлсэн  
•Сум хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн 2 зээлдэгчийн асуудлыг шийдвэрлүүлэхээр Говьсүмбэр аймаг дахь Сум дундын Иргэний Анхан шатны шүүхэд өгсөн.



## Худалдан авах ажиллагааны хүрээнд:

### Худалдан авах ажиллагаа Цахим тендер

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх, 2 харьцуулалтын аргаар зохион байгуулах “Иргэдэд үйлчлэх цэгийн тоног төхөөрөмж, 154, 152-р байрнуудын урд болон хажуу тал автомашины зосгоол хийх” тендерүүдийг 2022 оны 04 дүгээр сарын 14-ний өдөр нээлт хийсэн боловч тендерүүд амжилтгүй болсон. Үнэлгээний хорооны ажлын хэсэг хуралдаж 2022 оны 04-р сарын 25-ны өдөр дахин зарлахаар шийдвэрлэв.

### Худалдан авах ажиллагаа: Шууд худалдан авалт





## Хөдөө аж ахуйн ажлын хүрээнд:

### МАЛ ТӨЛӨЛТ, ТӨЛ БОЙЖИЛТЫН МЭДЭЭ

2022 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн байдлаар:

Нэр	Төллөх эх мал	Төлөлсөн эх мал	Хүлээн авсан төл						Төллөлтийн хувь	Бойжилтын хувь
Баянтал сум	26232	11065	19021						72,5%	100%
			Ботго3	Унага7	Тугал32	Хурга10629	Ишиг-8470	Ихэрлэлт-88		

Үүнээс хурга 77 ихэр, ишиг 43ихэр, нийт ихэр 120 толгой



## Коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд:

2022 оны 04 дүгээр сарын 08-ны өдрийн байдлаар 9 өвчтөн байна. Эрүүл мэндийн төвд их цэвэрлэгээг 3 удаа хийж ариутгалын бодисоор ариутгасан

- Вепатит вакцинд- 3
- Товлолт дархлаажуулалтанд6 хүүхэд
- 4-р тунгийн вакцинд- 2 иргэн
- Амбулторын үзлэг -14 иргэн хамрагдсан
- Хэвтэж эмчлүүлж байгаа -13 иргэн
- Ковид бүртгэгдээгүй, Ойрын хавьтал байхгүй
- PCR шинжилгээ- 0 иргэн
- Түргэвчилсэн шинжилгээ-2 иргэн
- Алсын дуудлага-3 иргэн
- Төвийн дуудлага-4 иргэн

Ерөнхий Сайдын санаачилсан “Илүүдэл жингүй-Эртэч монгол” аяны хүрээнд 2022 оны 04 дүгээр сарын 16 ний бямба гариг 5 байгууллагын 11 авто машинтай 54 хүний бүрэлдэхүүнтэй Чойрын богд ууланд нутгийн түүх, соёлын дурсгалт газруудтай танилцаж, байгууллагуудын албан хаагчдыг идэвхижүүлэх, эрүүл амьдралын зөв дадлыг бий болгох зорилгоор аялал, арга хэмжээ, нийтийн дасгал хөдөлгөөнийг зохион байгууллаа.

-2022 оны 4-р сарын 15-ний өдөр Боловсролын тусгай хэрэгцээ шаардлагатай байгаа хүүхдүүдийн хувийн ялгаатай байдал, хэрэгцээнд тулгуурлан боловсрол эзэмшүүлэх үйл явц ба нийгэмд хүлээн зөвшөөрөгдөх мөн тэднийг ялгаварлан гадуурхалыг зогсоож тэгш хамруулалтыг бий болгох багш, эцэг эх, иргэд хамтын ажиллагааг сайжруулах, санаа бодлоо солилцох зорилгоор Засаг даргын тамгын газрын иргэний танхимд 4-р сургууль, 4-р цэцэрлэг, Засаг даргын тамгын газар хамтран сургалт зохион байгуулж, Л.Отгонпүрэв, Б.Золзаяа, Б.Гандиймаа нар сургалт хийж мэдээлэл өглөө.

Уг сургалтад байгууллагуудын эцэг эхийн зөвлөл, сургууль, цэцэрлэгийн эцэг эхийн зөвлөл, иргэдийн төлөөлөл гээд 35 хүн хамрагдсан ба сургалтын нээлтийг Л.Гантөгс багшийн шавь нар 7-р ангийн сурагчид морин хуурийн татлага, Цэцэрлэгийн бэлтгэл бүлгийн хүүхдүүд “Цэцэрлэг минь сайн байна уу” дуугаар ая дуугаа өргөлөө.




#### **Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх вакцин, тандалт хяналт шалгалт судалгаа:**

2929 толгой үхэр хамрагдахаас одоогийн байдлаар 28 өрхийн 1080 мал хамрагдаж 36,7 хувьтай явж байна.

Шүлхий өвчний тандалт хяналт шалгалтын талаар 4-р сарын 21-22-ны өдрүүдэд сумын нутаг дэвсгэрээр 373 км явж 25 айл өрхөөр орж хаваржилт, цаг үеийн байдалтай танилцаж шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх гарын авлагаар хангаж ажилласан. Мөн хөдөөгийн айл өрхөөр явахдаа отор нүүдэл оруулахгүй бэлчээр чөлөөлөх, бэлчээрийн мэрэгч огтоно тархалтын байдлын судалгааг хийсэн.

Сумын 1-р багийн нутаг Тэрэгтийн тал, Мөнх толгой, 2-р багийн Шилийн хутгийн зүүн талаар огтоны тархалт ихэссээр байна.

Энэ онд суманд отор нүүдэлээр ирсэн аймаг сумын малчид өвөлжөөгүй, өвөлжилт хаваржилт өнөтэй сайхан орж малын хорогдол гараагүй сэг зэм үүсээгүй байна



#### **- ЕБС:**

2022 оны 04 дүгээр сарын 06-ны байдлаар манай сургуулийн хэжээнд өвчлөл шинээр бүртгэгдээгүй байна.

- Говьсүмбэр аймгийн Онцгой байдлын газарт хүсэлт гарган 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдөр багш ажилтан албан хаагчид болон 6-9 дүгээр ангийн сурагчдад галын аюулгүй байдал, газар хөдлөлтийн гамшигаас хэрхэн сэргийлэх, цар тахал, өвчлөлийн үед хэрхэн ажиллах тухай сургалтанд хамрагдлаа. Сургалтанд нийт 39 сурагч, 21 ажилтан албан хаагч хамрагдсан.
- Дотоодын /өөрийн/ нөөц бололцоогоо ашиглан 1.800.000 төгрөгийн шатар, даамны цэвэр модон ширээ сандлыг хийлгэн байршуулсан.

#### **СӨБ:**

- 3 бүлгийн нийт 72 хүүхэд хамрагдах бүртгэлтэй байгаагаас ирсэн-33 хүүхэд, өвчтэй-19 хүүхэд, чөлөөтэй-10 хүүхэд, тасласан-10 хүүхэд байна. ЕБСургууль амарсантай холбоотой хүүхдийн ирц багассан бөгөөд 1 өдрийн ирцийн хувь 45,8%-тай байна.
- Монгол Улсын Ерөнхий сайдын санаачилгаар иргэдийг идэвхитэй дасгал хөдөлгөөнд уриалсан “Илүүдэл жингүй -Эртэч Монгол” аяны хүрээнд СӨББ-н багш, ажилчдын дунд 2022 оны 04-р сарын 02-03-ны өдрүүдэд спортын арга хэмжээнд 14 багш, ажилчид идэвхитэй хамрагдсан.

**СТөв:**

- Соёл урлагийн арга хэмжээ-1, сургалт, тайлант хурал-3, нийт 4 арга хэмжээг техник хэрэгслээр ханган хамтран ажилласан.





ТАЙЛАН ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  В.ГАНТУЯА

ТАЙЛАН НЭГТГЭСЭН: 8522

ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН

 М.БОДЬГЭРЭЛ